

Монголын мэдлэгийн төвийн Ажлын алба

Ажлын албаны чиг үүрэг

Мэдлэгийн төвийн Ажлын албаны үүргийг амжилттай биелүүлэхэд шаардлагатай дараах чадавхыг бүрдүүлэх, бэхжүүлэхэд оршино. Үүнд:

- Монголын мэдлэгийн төвийн цахим платформыг үр дүнтэй ажиллуулах,
- Бичил уурхайн сүлжээг бэхжүүлэх зорилгоор оролцогч талуудыг хамтын ажиллагааг дэмжих, зохицуулах замаар нэгтгэх,
- Оролцогч талуудын мэдлэг хуваалцах, суралцах, чадавх бэхжүүлэх санаачлагуудыг дэмжих,
- Бичил уурхайн холбогдолтой мэдээлэл, тоо баримтыг цуглуулах, бичиг баримтжуулах ажлыг хариуцах,
- Гишүүдээс гарсан сайн туршлагыг баримтжуулах санаачлагыг дэмжих,
- Гишүүдийн бичил уурхайн үйл ажиллагааг сурталчлах, дэмжих санаачлагыг хөгжүүлэх, дэмжих.

Ажлын албаны үүрэг нь оролцогч талуудын үр дүнтэй хамтын ажиллагааг хангах зохицуулалт хийх, мэдлэг мэдээллийг түгээхэд оршино. Тогтвортой бичил уурхай төслийн (ТБУТ) хэрэгжилтийн хугацаанд Ажлын алба нь Мэдлэгийн төв, харилцааны эксперт болон Датаком компанитай хамтарч ажиллана. Тогтвортой бичил уурхай төслийн экспертүүдтэй хамтран Ажлын алба сэдэвчилсэн бүлгүүдэд хурал, уулзалт, семинар болон бусад арга хэмжээ зохион байгуулахад нь дэмжлэг үзүүлнэ.

Мэдлэгийн төв өөрийн цахим шуудангийн хаяг, нийгмийн сүлжээний групп үүсгэсэн байх бөгөөд оролцогч талуудыг хамруулсан уулзалтуудыг тогтмол зохион байгуулж мэдлэгийн төвийн сүлжээний үйл ажиллагааг дэмжин ажиллана. Мэдлэгийн төвийн мэдээллийг түгээх ерөнхий хэрэгсэл нь цахим хуудас, мэдээллийн сан, нөөц болон мэдлэгийг хуваалцах, солилцох арга хэмжээ болох туршлага судлах аялал, семинар зохион байгуулах, газар дээрх болон цахим сургалт, уулзалтууд байна.

Зохицуулалт ба менежмент

- Мэдлэгийн төвийн үйл ажиллагааны стратеги боловсруулах,
- Мэдлэгийн төвийн тогтвортой үйл ажиллагааг хариуцан ажиллах,
- Мэдлэгийн төвийн 1,5 жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон төсвийг тооцоолон боловсруулж Удирдах зөвлөлөөр батлуулах,
- Улирал бүр тайлан бэлдэж Удирдах зөвлөлд хүргэх

Мэдлэг хуваалцах, харилцаа холбоо ба сүлжээ үүсгэх

- Мэдлэгийн төвийн үйл ажиллагааны дотоод харилцаа холбоог бий болгох,
- Гадаад харилцаа, бичил уурхайн үйл ажиллагааг сурталчлах, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх,
- Бичил уурхайн мэдлэгийн төвийн янз бүрийн түвшний оролцогч талуудын хамтын ажиллагааг идэвхижүүлэх,
- Бичил уурхайн олон улсын мэдлэгийн төвтэй хамтын ажиллагааг бэхжүүлэх,

Хөрөнгө босгох ба нөлөөллийн ажил

- Бичил уурхайн чиглэлээр бодлогын түвшний харилцагч нарыг Мэдлэгийн төвийн үйл ажиллагаанд хамруулах,
- Бичил уурхайн мэдлэгийн төвийн бизнес үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах,

- Хувийн хэвшлийн байгууллагууд болон уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудыг Бичил уурхайн мэдлэгийн төвийн үйл ажиллагаанд татан оруулах боломжийг эрж хайх,
- Бусад ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг төсөл хөтөлбөртэй үйл ажиллагаагаа уялдуулах боломжийг эрж хайх,
- Бичил уухайн чиглэлээр Үндэсний түвшинд лобби хийх, нөлөөллийн ажлыг сэдэвчилсэн бүлгүүдийн ахлагч нартай хамтран зохион байгуулах,

Үр дүн

Монголын мэдлэгийн төвийн Ажлын алба мэдлэгийн төвийн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлснээр Тогтвортой бичил уурхай төслийн логфрамед тусгасан үр дүн III-ын биелэлтэд хувь нэмэр оруулна.

- Монголын мэдлэгийн төв өөрийн гэсэн хэрэглэгчид, гишүүдтэй байна. Хэрэглэгчид болон гишүүд бичил уурхайн талаар хамгийн сүүлийн үеийн шинэлэг мэдээлэл авах боломжтой байна. Жил бүр дор хаяж 1,000-1,500 хэрэглэгчид хүрнэ.
- Мэдлэгийн төвийн Ажлын албаны удирдлага болон байгууллагын чадавхи бэхжиж сэдэвчилсэн бүлэг бүрээр байгууллага, иргэдтэй хамтын ажиллагаа, сүлжээ үүсгэнэ. Мөн түүнчлэн бүх шатны төрийн байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтооно.
- Монголын мэдлэгийн төвийн үйл ажиллагаагаар дамжуулан бичил уурхай талаарх олон нийтийн ойлголт хандлага эерэгээр өөрчлөгдөнө.
- Монголын бичил уурхайн салбарт бүрдсэн сайн туршлага, сурсан сургамжыг олон улсын бичил уурхайн талбарт хүргэнэ.

Тайлагнах

Ажлын алба Мэдлэгийн төвийн Удирдах зөвлөл, Тогтвортой бичил уурхай төслийн (ТБУТ) удирдлагын багт үйл ажиллагааны тайланг хүргэнэ.

Монголын мэдлэгийн төвийн Ажлын алба үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг жилд дор хаяж хоёр удаа Англи, Монгол хэлээр бэлтгэж мэдлэгийн төвийн Удирдах зөвлөл болон бусад холбогдох байгууллагуудад хүргэнэ. Мэдлэгийн төвийг байгуулах үйл ажиллагаа болон менежментийн асуудлыг Тогтвортой бичил уурхай төслийн удирдлагын баг, Мэдлэгийн төв, харилцааны мэргэжилтэн тогтмол хянаж, үнэлнэ.